



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Огноо: 2022. 01. 24

№ 22/08

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хойшлуулах тухай

Компанийн тухай хуулийн 60, 61 дүгээр зүйлийн холбогдох заалтууд, Банкны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.4, Богд Банкны дүрмийн 8 дугаар зүйлийн 8.14.5 заалтуудыг тус тус үндэслэн Монголбанкны Ерөнхийлөгчийн 2017 оны 10 дугаар сарын 30-ны №А-276 тоот тушаалаар арилжааны банкуудын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх тухай заалтыг хэрэгжүүлэх хугацааг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний А-373 тоот тушаалаар сунгаснаар Богд банк ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр хуралдуулахаар зарлах үед мэдэх боломжгүй байсан буюу шинээр үүссэн хууль эрх зүй, зохицуулалтын орчны өөрчлөлтийг харгалzan **ТОГТООХ НЬ:**

1. 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр хуралдуулахаар зарласан Богд банк Хувьцаат Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хойшлуулсугай.

2. Богд банк Хувьцаат Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцүүлэхээр тогтоосон Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж, дүрэмд өөрчлөлт оруулах, Компанийн ТҮЗ-ийн гишүүн, хараат бус гишүүдийг нөхөн бүрдүүлэх тухай асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны ээлжит хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэхээр тогтоосугай.

3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх хэсэгт заасан хугацаанд багтаан хуралдуулахыг тус Банкны Төлөөлөн Удирдах Зөвлөл (Л.Болдхуяг)-д даалгасугай.

4. Энэхүү тогтоол гарсантай холбоотойгоор ТҮЗ-ийн 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 21/128 тоот “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зарлан хуралдуулах тухай” тогтоолыг хүчингүйд тооцсугай.

5. 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 21/124 тоот “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зарлан хуралдуулах тухай” тогтоолыг хүчингүйд тооцсонтой холбоотойгоор холбогдох залруулга мэдээлэл гаргах, холбогдох байгууллагад мэдээлэл хүргэхийг Хурал зохион байгуулах комисс (С.Оргодол)-т үүрэг болгосугай.

6. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэх захирал Г.Саруул/-т даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.БОЛДХУЯГ